



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРХАН-УУЛ АЙМАГ
ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР-445 ДУГААР НЭЭЛТТЭЙ
ХОРИХ АНГИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/20/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар

Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	18
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХЗДХЯ	Хууль зүйн дотоод хэргийн яам
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



ШШГЕГ-ЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗАР-445 ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ
АНГИЙН ДАРГА Д.ӨЛЗИЙБАТ ТАНАА

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.18 № 41

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд нийт давхардсан тоогоор 377 хоригдлыг ажлын байраар хангаж, олгосон 214,592.6 мянган төгрөгийн цалинг нэрийн дансанд хөтөлж, шүүхийн төлбөрт шүүхийн төлбөрт 27,560.1 мянган төгрөг барагдуулсан ажил гүйлгээг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 43.1 хувиар өсжээ.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 53 арга хэмжээ төлөвлөснийг ШШГЕГ-аас хэрэгжилтийг 96.8 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4525020044

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>323,170,584.10</u>	<u>299,823,400.26</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	26,343,532.47	39,708,948.89
Банкинд байгаа бэлэн мөнгө	26,343,532.47	39,708,948.89
Төгрөг	26,343,532.47	39,708,948.89
Төрийн сангийн харилцах	26,343,532.47	39,708,948.89
АВЛАГА	5,586,400.00	8,687,000.00
Бусад авлага	5,586,400.00	8,687,000.00
Байгууллагаас авах авлага	5,586,400.00	8,687,000.00
БАРАА МАТЕРИАЛ	291,240,651.63	251,427,451.37
Түүхий эд материал	68,601,357.91	52,453,369.73
Тусгай зориулалттай материал	64,455,327.91	48,626,423.73
Эм боох материал	4,146,030.00	3,826,946.00
Дуусаагүй үйлдвэрлэл	3,419,100.00	-
Бэлэн бүтээгдэхүүн	12,687,239.51	16,042,725.60
Хангамжийн материал	125,322,954.21	87,776,356.04
Бичиг хэргийн материал	12,966,646.13	6,767,996.13
Аж ахуйн материал	53,192,528.20	39,432,983.91
Түлш, шатах тослох материал	11,042,500.00	7,639,000.00
Хүнсний материал	29,808,943.51	22,792,518.25
Бусад хангамжийн материал	18,312,336.37	11,143,857.75
Мал амьтад	81,210,000.00	95,155,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,388,152,618.99</u>	<u>3,251,167,109.82</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,388,152,618.99	3,251,167,109.82
Биет хөрөнгө	2,257,215,535.70	2,121,573,359.82
Барилга, байгууламж, орон сууц	2,459,283,997.37	2,459,283,997.37
Хуримтлагдсан элэгдэл	(582,402,066.76)	(701,968,178.83)
Авто-тээврийн хэрэгсэл	229,044,897.00	177,926,500.00
Хуримтлагдсан элэгдэл	(141,084,525.24)	(74,942,197.78)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	436,296,274.82	474,474,894.82
Хуримтлагдсан элэгдэл	(192,708,417.08)	(278,760,858.31)
Тавилга, аж ахуйн эд хогшил	83,834,193.10	114,443,398.10
Хуримтлагдсан элэгдэл	(49,518,817.51)	(63,354,195.55)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	14,470,000.00	14,470,000.00
Биет бус хөрөнгө	1,130,937,083.29	1,129,593,750.00
Программ хангамж	6,310,000.00	6,310,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(3,122,916.71)	(4,466,250.00)
Бусад биет бус хөрөнгө	1,127,750,000.00	1,127,750,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,711,323,203.09</u>	<u>3,550,990,510.08</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>19,879,032.47</u>	<u>37,355,906.54</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,879,032.47	37,355,906.54
Өглөг	19,879,032.47	37,355,906.54
Бусад өглөг	19,879,032.47	37,355,906.54

Байгууллагад төлөх өглөг	-	150,000.00
Хувь хүмүүст төлөх өглөг	19,879,032.47	37,205,906.54
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,691,444,170.62</u>	<u>3,513,634,603.54</u>
Засгийн газрын хувь оролцоо	3,691,444,170.62	3,513,634,603.54
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,624,921,893.90	1,624,921,893.90
Өмч: - төрийн	1,624,921,893.90	1,624,921,893.90
Хуримтлагдсан үр дүн	106,642,665.82	(71,166,901.26)
Өмнөх үеийн үр дүн	353,426,812.80	106,642,665.82
Тайлант үеийн үр дүн	(246,784,146.98)	(177,809,567.08)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,959,879,610.90	1,959,879,610.90
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,711,323,203.09</u>	<u>3,550,990,510.08</u>




2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,511,210,105.50	3,412,480,416.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	257,669,765.50	463,092,881.57
120	Нийтлэг татварын бус орлого	257,669,765.50	463,092,881.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	253,829,765.50	463,092,881.57
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	207,480,892.00	284,989,947.17
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	46,348,873.50	178,102,934.40
120005	Түрээсийн орлого	3,840,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,253,540,340.00	2,949,387,535.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,179,765,800.00	2,895,510,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,179,765,800.00	2,895,510,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,774,540.00	53,877,035.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,054,540.00	42,880,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,720,000.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		997,035.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,757,994,252.48	3,550,873,316.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,757,994,252.48	3,550,873,316.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,545,111,626.13	3,333,834,969.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,581,806,135.45	2,263,854,800.00
210101	Үндсэн цалин	1,000,379,507.96	1,259,036,671.51
210102	Нэмэгдэл	484,162,767.73	824,341,528.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,093,000.00	122,934,000.00
210104	Урамшуулал	55,170,859.76	57,542,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,677,039.83	46,372,757.29
210201	Тэтгэврийн даатгал	-	600,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	80,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	35,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	30,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,677,039.83	45,627,757.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,030,700.00	169,546,907.46
210301	Гэрэл, цахилгаан	74,913,925.15	83,689,406.87
210302	Түлш, халаалт	62,469,474.85	68,258,900.00
210303	Цэвэр, бохир ус	17,647,300.00	17,598,600.59
2104	Хангамж, бараа материалын зардал	109,177,326.83	163,733,496.74
210401	Бичиг хэрэг	2,121,630.00	4,259,830.00
210402	Тээвэр, шатахуун	24,460,740.00	38,457,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	3,239,099.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	171,200.00	171,200.00

ХТ05430 @ 8922288

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,114,807.03	689,498.97
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	38,602,429.39	59,421,638.91
210408	Бараа материал акталсны зардал	32,706,520.41	57,495,229.47
2105	Нормативт зардал	233,807,248.21	309,175,276.96
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,856,481.87	5,178,073.00
210502	Хоол, хүнс	230,950,766.34	302,928,425.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,068,778.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,402,015.00	59,312,215.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,555,420.00	815,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,139,795.00	1,645,000.00
210604	Урсгал засвар	85,706,800.00	56,852,215.00
2107	Томилолт, зочны зардал	482,500.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	482,500.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,448,500.00	28,793,028.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,100,000.00	21,209,995.51
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	330,533.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	198,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,554,500.00	4,840,500.00
210807	Газрын төлбөр	2,214,000.00	2,214,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	318,280,160.81	292,546,487.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,420,701.27	37,685,720.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,008,500.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	255,850,959.54	254,860,767.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	212,882,626.35	217,038,347.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	162,484,200.00	109,263,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	144,239,200.00	74,497,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,245,000.00	34,766,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	286,525.07	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	286,525.07	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,111,901.28	107,775,347.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,111,901.28	107,775,347.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(246,784,146.98)	(138,392,900.24)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	39,416,666.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		39,416,666.84
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(39,416,666.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(246,784,146.98)	(177,809,567.08)




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,690,020,872.11</u>	<u>3,603,280,517.70</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	436,480,532.11	653,892,982.70
120	Нийтлэг татварын бус орлого	436,480,532.11	653,892,982.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	426,260,032.11	649,654,440.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	426,260,032.11	649,654,440.35
120005	Түрээсийн орлого	3,840,000.00	3,840,000.00
120009	Бусад орлого	6,380,500.00	398,542.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,253,540,340.00	2,949,387,535.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,179,765,800.00	2,895,510,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,179,765,800.00	2,895,510,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,774,540.00	53,877,035.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,054,540.00	42,880,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,720,000.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	997,035.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,661,704,914.37</u>	<u>3,552,669,396.28</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,661,704,914.37	3,552,669,396.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,480,982,288.02	3,327,010,049.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,588,186,635.45	2,263,854,800.00
210101	Үндсэн цалин	1,000,379,507.96	1,259,036,671.51
210102	Нэмэгдэл	490,543,267.73	824,341,528.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,093,000.00	122,934,000.00
210104	Урамшуулал	55,170,859.76	57,542,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,677,039.83	46,438,800.00
210201	Тэтгэврийн даатгал	-	600,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	80,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	35,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	30,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,677,039.83	45,693,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,023,200.00	169,850,135.00
210301	Гэрэл, цахилгаан	74,913,925.15	83,797,035.00
210302	Түлш, халаалт	69,461,974.85	68,453,100.00
210303	Цэвэр, бохир ус	17,647,300.00	17,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,948,140.00	47,490,300.00
210401	Бичиг хэрэг	2,883,800.00	3,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	33,051,640.00	38,280,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	3,239,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	171,200.00	171,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,841,500.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	216,960,699.65	288,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,035,700.00	6,000,000.00
210502	Хоол, хүнс	211,924,999.65	282,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,901,200.00	79,282,295.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,038,900.00	10,822,295.00
210602	Тавилга	-	180,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,719,800.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	94,142,500.00	65,280,000.00
2107	Томилолт, зочны зардал	482,500.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	482,500.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	269,030,682.37	376,153,719.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	261,396,182.37	368,431,219.11
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	470,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	198,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,840,500.00	4,840,500.00
210807	Газрын төлбөр	2,214,000.00	2,214,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,772,190.72	55,440,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,763,690.72	55,440,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,008,500.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,722,626.35	225,659,347.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	162,484,200.00	109,263,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	144,239,200.00	74,497,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,245,000.00	34,766,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	286,525.07	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	286,525.07	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,951,901.28	116,396,347.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,951,901.28	116,396,347.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>28,315,957.74</u>	<u>50,611,121.42</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,826,100.00	37,245,705.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,826,100.00	37,245,705.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,826,100.00	37,245,705.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	11,826,100.00	37,245,705.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(11,826,100.00)</u>	<u>(37,245,705.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,624,921,893.90	1,965,202,799.37	348,103,624.33	3,938,228,317.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,624,921,893.90	1,965,202,799.37	348,103,624.33	3,938,228,317.60
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			(246,784,146.98)	(246,784,146.98)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,624,921,893.90	1,965,202,799.37	101,319,477.35	3,691,444,170.62
D01	2024 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,624,921,893.90	1,965,202,799.37	(145,464,669.63)	3,691,444,170.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,624,921,893.90	1,965,202,799.37	101,319,477.35	3,691,444,170.62
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			(177,809,567.08)	(177,809,567.08)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,624,921,893.90	1,965,202,799.37	(76,490,089.73)	3,513,634,603.54



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,068,250,500.00	3,068,250,500.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,068,250,500.00	3,068,250,500.00	-	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,973,347,500.00	2,973,347,500.00	-	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,263,854,800.00	2,263,854,800.00	-	100.00
210101	Үндсэн цалин	1,146,799,300.00	1,259,036,671.51	112,237,371.51	109.79
210102	Нэмэгдэл	936,578,900.00	824,341,528.49	(112,237,371.51)	88.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	122,934,000.00	122,934,000.00	-	100.00
210104	Урамшуулал	57,542,600.00	57,542,600.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,438,800.00	46,438,800.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	600,000.00	600,000.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	80,000.00	80,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,000.00	35,000.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	30,000.00	30,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,693,800.00	45,693,800.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,853,100.00	168,853,100.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	82,800,000.00	82,800,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	68,453,100.00	68,453,100.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	17,600,000.00	17,600,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,490,300.00	47,490,300.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	3,300,000.00	3,300,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	38,280,000.00	38,280,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,239,100.00	3,239,100.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	171,200.00	171,200.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	288,000,000.00	288,000,000.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	282,000,000.00	282,000,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,648,000.00	73,648,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,248,000.00	25,248,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	45,400,000.00	45,400,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	-	100.00




2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,122,500.00	29,122,500.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,400,000.00	21,400,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	470,000.00	470,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	198,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,840,500.00	4,840,500.00	-	100.00
210807	Газрын төлбөр	2,214,000.00	2,214,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,440,000.00	55,440,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,440,000.00	55,440,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,903,000.00	94,903,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,903,000.00	94,903,000.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	74,497,000.00	74,497,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,406,000.00	20,406,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,068,250,500.00	3,147,726,847.17	79,476,347.17	102.59
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,895,510,500.00	2,895,510,500.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,895,510,500.00	2,895,510,500.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	172,740,000.00	252,216,347.17	79,476,347.17	146.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	168,655,000.00	248,376,347.17	79,721,347.17	147.27
1200042	Үндсэн бус үйл ажиллагааны бусад орлого	245,000.00	-	(245,000.00)	-
120005	Төрийн өмч түрээслүүлсний орлого	3,840,000.00	3,840,000.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	26,343,532.47	26,343,532.47	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	39,708,948.89	39,708,948.89	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	84.00	80.00	(4.00)	95.24
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	81.00	78.00	(3.00)	96.30
620003	Үйлчлэх ажилтан	1.00	-	(1.00)	0.00
620004	Гэрээт ажилтан				



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,877,035.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,877,035.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,877,035.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	997,035.00
210301	Гэрэл, цахилгаан	997,035.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,880,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,975,000.00
210602	Тавилга	6,025,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-
210604	Урсгал засвар	19,880,000.00
2107	Томилолт, зочны зардал	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,877,035.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,877,035.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,880,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	997,035.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ШШГЕГ-ын харьяа ШШГГ-445 дугаар нээлттэй хорих анги нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус хорих анги нь тайлант онд “Байгууллагын соёлыг төлөвшүүлж, ахлагчийн манлайллыг дэмжих” жилийн хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Орчин үеийн удирдлагын шинэлэг арга барилыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, ёс зүйг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх
- Ахлагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах
- Цэргийн албаны зохион байгуулалтыг жигдрүүлж, цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

ШШГЕГ-ын ШШГГ-445 дугаар нээлттэй хорих анги нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль*
- *Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор цалингийн доод хэмжээг шинэчлэн баталсан*

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ШШГЕГ-ын ШШГГ-445 дугаар нээлттэй хорих ангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ШШГЕГ-ын ШШГГ-445 дугаар нээлттэй хорих ангийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160,332.7 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,343.5	39,708.9	13,365.4
Авлага	5,586.4	8,687.0	3,100.6
Бараа материал	291,240.6	251,427.5	(39,813.1)
Үндсэн хөрөнгө	3,388,152.6	3,251,167.1	(136,985.5)
Нийт хөрөнгө	3,711,323.2	3,550,990.5	(160,332.7)
Өр төлбөр	19,879.0	37,355.9	17,476.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,691,444.2	3,513,634.6	(177,809.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,711,323.2	3,550,990.5	(160,332.7)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн дансанд 39,708.9 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл 2,503.0 мянган төгрөг, харин хоригдлын нэрийн дансанд бүртгэсэн 37,205.9 мянган төгрөг байна.

Авлагын дансны үлдэгдэл нь оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлд 66.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн, ШШГЕГ-т 8,621.0 мянган төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлснээр нийт 8,687.0 мянган төгрөгийг авлага бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өнгөрсөн оноос буурахад ШШГЕГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/159 тоот тушаалаар 330 нэр төрлийн 40,828.2 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө акталсан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс буурсан нь төсвийн хөрөнгөөр 14,625.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, хандив тусламжаар ШШГЕГ-аас 10,763.7 мянган төгрөгийн иж бүрэн компьютер, ХЗДХЯ-аас 75,900.0 мянган төгрөгийн фургон тээврийн хэрэгсэл, Хорих ял эдлүүлэх албанаас 21,732.5 мянган төгрөгийн ширээ сандал, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2024 оны 30, 44 дүгээр тогтоолуудаар 22,620.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, ТӨБЗГ-ын 2024 оны 307 дугаар тогтоолоор 5 нэр төрлийн 11,650.0 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон, 2,604.1 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 51,018.4 мянган төгрөгийн автомашин акталж данснаас хассан, 254,860.8 мянган төгрөгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалжээ.

Өр төлбөр өссөн нь хоригдлын нэрийн дансанд төвлөрсөн цалин, ар гэрээс шилжүүлсэн 37,205.9 мянган төгрөг, нэр данс зөрүүтэй 150.0 мянган төгрөг бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг 2,718,303.2 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс 2,573,776.6 мянга, дотоод орлогоос

144,526.6 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөн, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02 тоот албан бичгээр 2,908,053.6 мянган төгрөгөөр баталсныг тайлант оны 06 дугаар сард цалингийн өсөлт, зах зээлийн үнийн өсөлт, буцалтгүй тусламж, нэг удаагийн тэтгэмж олгохтой холбоотойгоор 160,196.9 мянган төгрөг нэмж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 3,068,250.5 мянган төгрөгийн 94.4 хувийг улсын төсвөөс, 5.6 хувийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,895,510.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 252,216.3 мянган төгрөгийн орлого олж, нийт 3,147,726.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Урсгал үйл ажиллагаанд 3,068,250.5 мянган төгрөг зарцуулж, давсан орлого 79,476.3 мянган төгрөгийг ШШГЕГ-т төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,068,250.5 мянган төгрөг буюу 100.0 хувьтай гарсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	70705- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	3,068,250.5	3,068,250.5	-	100.0
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	2,848,983.3	2,848,983.3	-	100.0
2	80102- Туслах үйл ажиллагааны зардал	117,940.0	117,940.0	-	100.0
3	80229- Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	6,424.2	6,424.2	-	100.0
4	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	94,903.0	94,903.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус газрын бүтэц, орон тоо баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал А/172 дугаар тушаалаар 83 орон тоо баталснаас гүйцэтгэлээр 80 албан хаагч ажилласан байна. Тайлант онд төсвийн зарцуулаагүй үлдэгдлээс ахмадын сангийн харилцах дансанд 398.5 мянган төгрөг төвлөрүүлж, 4,360.0 мянган төгрөг зарцуулжээ. Батлагдсан төсвөөс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 21,400.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 55,440.0 мянган төгрөг тус тус төлөвлөж, 100 хувь зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас оны тэргүүний шийдвэр гүйцэтгэх байгууллагаар шагнаж хуваарилсан 10,000.0 мянган төгрөгийг хамт олны шийдвэрээр ажлын байранд хүүхдийн өрөө бий болгож засвар хийсэн, Дархан-Уул аймгийн Гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх салбар зөвлөлийн тогтоолоор 23,000.0 мянган төгрөг, Хонгор сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 19,880.0 мянган төгрөгийн санхүүжилтийг суллагдахын өмнөх байрны завсар, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслийг авахад зарцуулжээ. Мөн ШШГЕГ-аас өгсөн зөвшөөрлийн дагуу аймгийн Цагдаагийн газартай байгуулсан гэрээгээр баривчлах байрыг түрээслүүлэн тогтмол зардал 997.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд ШШГЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 96м² талбайтай өрөөг “Хоригдлыг суллагдахад бэлтгэх байр” болгон засварлаж ашиглалтад оруулснаар хорих ангиас суллагдсан 15 иргэнийг нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг хангах, дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтаар 1 төсөл, арга хэмжээний 280,000.0 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 2 төсөл, арга хэмжээний 60,400.0 мянган төгрөг, нийт 340,400.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3 төсөл, арга хэмжээнд 305,010.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, хуульд нийцүүлэн ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ШШГЕГ-ын ШШГГ-445 дугаар нээлттэй хорих ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн шилэн дансны болон цалингийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Г.Батмягмар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

ШШГЕГ-ын ШШГГ-445 дугаар нээлттэй хорих ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/165 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 2,976,162.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,761.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой заавал шалгах хамааралтай асуудлуудыг шалгахад алдаа зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 49,300.8 мянган төгрөгийн 11 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан, алдаа, зөрчил илрээгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,639.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажиллах зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага 5 албан хаагчид шагнал олгохдоо цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-тай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх

Тайлангийн 4.4.1-т дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил болон дээрх зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
			-	-					-	-	-	-
Дүн			-	-					-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан хаагчдад олгосон мөнгөн шагналыг цалингийн зардлаас олгосон	1	3,639.5	-	-	-	-	1	3,639.5	-	-	-	-
Дүн	1	3,639.5	-	-	-	-	1	3,639.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 6 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 5 тушаал, шийдвэр мэдээлээгүй байна	1	49,300.8	-	-	-	-	1	49,300.8
Дүн	1	49,300.8	-	-	-	-	1	49,300.8